



“СОЛОНГО ЭКСПРЕСС”
КОМПАНИЙН УДИРДЛАГАД

АКПАР АУДИТ ХХК

Огноо 2013.02.08

Дугаар 267

ГХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “Солонго-Экспресс” ХК-ийн 2012 оны 12-р сарын 31-ний Санхүүгийн тайлан буюу Үлдэгдэл тэнцэл, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангуудыг шалгалаа.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын үүрэг хариуцлага

Хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахын тулд санхүүгийн тайлангаа бодитой, шударгаар бэлтгэж, танилцуулах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Түүнчлэн байгууллагын хөрөнгийг зохих горимын дагуу хадгалах, хамгаалах, зориулалтын бус зүйлд зарцуулахгүй байх нь мөн удирдлагын хүлээх хариуцлага юм.

Аудиторын үүрэг хариуцлага

Аудиторын үүрэг хариуцлага бол тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь бодитой, шударгаар илэрхийлэгдсэн гэдгийг нотлох явдал билээ.

Өөрөөр хэлбэл тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, баримт боловсруулах, санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартыг зөрчөөгүй гэсэн нотолгоо олж авах явдал юм.

Үүний тулд урьдчилж бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу компанийн ажилтнуудаас асууж тодруулах, тооцооллуудыг дахин хянах, мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийн дансуудын зарим гүйлгээг түүвэрлэн шалгах, компанийн боловсруулсан гүйлгээ баланс, хураангуй бүртгэлийг санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдтэй тулган шалгах зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг.

Аудитын дүгнэлт

Бидний дүгнэлтээр “Солонго-Экспресс” ХК-ийн 2012 оны 12-р сарын 31-ээр тасалбар болгож гаргасан жилийн санхүүгийн тайланд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт болон Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох заавар, журмыг зөрчсөн гэж үзэхэд хүргэх ямар нэгэн материаллаг алдаа, зорчил ажиглагдаагүй болно.



АКПАР ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

TTC0344-5229979

Х.БАЯНБАЙ

Санхүүгийн тайланын 1-р байр: Баянзүрх дүүрэг, 1-р хороо Монголын ХАА-н Хоршоологчдын үндэсний холбооны байр 209,210 тоот.

Утас/Факс: 976-11-462131, 976-91919758

Санхүүгийн тайланын 2-р байр: Баянзүрх дүүрэг, 6-р хороо Кекүншио цамхаг, 7 давхар, 706 тоот. Утас: 976-50884272, 976-99121599

И-майл: akpar.audit@gmail.com

СОЛОНГО ЭКСПРЕСС ХХК
ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЭЛ
2012 оны 12 сарын 31-нээр

ХӨРӨНГӨ		Тод	31/12/2011	(төгрөг) 31/12/2012
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	35,177,100	35,177,100	
Дансны авлага	4	22,200	22,200	
Бусад авлага		62,134,199	62,134,199	
Эргэлтийн хөрөнгийн дүн		97,333,499	97,333,499	
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө		30,497,000	-	
Хуримтлагдсан элэгдэл		(19,272,176)	-	
Биет бус хөрөнгө		-	74,990,097	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		11,224,824	74,990,097	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			108,558,323	172,323,597
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ		Тод	31/12/2011	31/12/2012
Богино хугацаат өр толбөр				
ХАОАТ-ын өглөг		60,000	60,000	
Бусад татварын өглөг		4,994,100	-	
Бусад өглөг		30,000,000	36,006,100	
Богино хугацаат өр толбөр		35,054,100	36,066,100	
Эзний өмч				
Эзэмшигчдийн өмч		15,652,300	15,652,300	
Дахин үнэлгээний нөөц	5	143,334,238	218,324,335	
Хуримтлагдсан ашиг		(85,482,315)	(97,719,139)	
Эзний өмчийн дүн		73,504,223	136,257,497	
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН			108,558,323	172,323,597



СЕБАСТЬЕН МАРНЕУР

А.МӨНХЧИМЭГ

**СОЛОНГО ЭКСПРЕСС ХХ
ОРЛОГО УР ДҮНГИЙН ТАЙЛАН
2012 оны 12 сарын 31-нээр**

(Төгрөг)

ОРЛОГО	Тод	31/12/2011	31/12/2012
Борлуулалтын орлого		8,905,736	-
Үйл ажиллагааны зардал	6	29,227,500	310,000
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЛДАГДАЛ		(20,321,764)	(310,000)
Үндсэн бус үйл ажиллагааны алдагдал		(3,039,976)	(702,000)
Татварын өмнөх алдагдал		(23,361,740)	(1,012,000)
Татварын дараах алдагдал		(23,361,740)	(1,012,000)
Тайлант үеийн цэвэр алдагдал		(23,361,740)	(1,012,000)



СЕБАСТЬЕН МАРНЕУР

А.МӨНХЧИМЭГ

Хавсаргасан тодруулга нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

**СОЛОНГО ЭКСПРЕСС ХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2012 оны 12 сарын 31-нээр**

(Төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2011 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,652,300	143,334,238	(85,482,315)	73,504,223
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт	-	74,990,097	-	-
Орлогын тайландаа хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	(11,224,824)	(11,224,824)
Тайлант үеийн алдагдал	-	-	(1,012,000)	(1,012,000)
2012 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,652,300	218,324,335	(97,719,139)	62,279,399



Хавсаргасан тодруулга нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

**СОЛОНГО ЭКСПРЕСС ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
2012 оны 12 сарын 31-нээр

(Төгрөг)

	31/12/2011	31/12/2012
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого		
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	-	-
Бусад үйл ажиллагаанаас орсон орлого	39,158,356	-
Дүн	39,158,356	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага		
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	711,000	-
Түлш шатахууны тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	-	58,000
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	1,814,881	252,000
Төлсөн орлогын татвар	-	4,994,100
Бусад үйл ажиллагааны мөнгөн зарлага	6,954,722	702,000
Дүн	9,480,603	6,006,100
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	29,677,752	(6,006,100)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зээл	-	6,006,100
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	6,006,100
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	29,677,752	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,499,348	35,177,100
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,177,100	35,177,100



Хавсаргасан тодруулга нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг мөн.

**СОЛОНГО ЭКСПРЕСС ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ
2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР**

A. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уг компани 1992 онд “Түүхий эд бэлтгэлийн анги” нэртэйгээр Монгол Улсын бүх аймаг сумдад өөрийн салбарaa нээн мал амьтны гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор байгуулагдсан ууган аж ахуйн нэгжүүдийн нэг бөгөөд 1991 онд Улаанбаатар хотын АДХГЗ-ны өмч хувьчлалын комиссын шийдвэрээр үйлдвэрлэл худалдааны “Солонго импекс” төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болон байгуулагдсан. 2005 оны 1 сарын 19-ний өдөр оноосон нэрээ “Солонго Экспресс” ХК болгон өөрчилсөн.

Монгол Улсын Засгийн Газрын 1997 оны 160-р тогтоолын 5-р зүйлийн 13а заалтын дагуу 1998 оны 11-р сарын 09-ний нийслэлийн өмчийн газрын дуудлага худалдаагаар төрийн мэдлийн 51 хувь буюу 79'827 ширхэг хувьцааг худалдан авсан.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байсан ба үндсэн үйл ажиллагаа нь байрын болон талбайн түрээс, гадаад, дотоод худалдаа, тээвэр зуучийн үйл ажиллагаа явуулахад бэлтгэгдсэн.

Хувьчилж авснаас хойшхи хугацаанд компани өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн импорт экспортын тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаанууд явуулж ирсэн. 2005 оныг хүртэлх хугацаанд компани нь 14'427 м.кв эзэмшил газар бүхий албан контор, автомашины гараж, агуулахын зориулалттай барилга, салаа төмөр зам зэрэг тухайн үеийн ханшаар нийт 271'034'000 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгөтэй, 11 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байв.

2005-2007 онуудад өөрсдийн бааз суурь, давуу талууд дээрээ тулгуурлан олон улсын тээвэр зуучын үйл ажиллагаа эрхлэхээр шаардлагатай бэлтгэл ажлуудыг хийж, тээвэр зуучийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн өргөдлөө гаргасан. Шинэчилсэн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах бэлтгэлээ хангасан байсан ч санхүүгийн хямралын улмаас тус төлөвлөгөө бүрэн хэрэгжиж чадаагүй зогсонги байдалд орсон гэж одоогийн удирдлага үзэж байна.

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (СТОУС) -ын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын Сангийн Яамнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн журмуудын даган мөрдсөн байна.

Санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын Төгрөг (“Төг”)-өөр, түүхэн өртгийн зарчмын дагуу илэрхийлэгдсэн.

Бэлтгэсэн суурь

Төгрөгөөр илэрхийлэгдсэн Төслийн Санхүүжилт, Зарцуулалтын Тайлан нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн орлого, зарлагын сууриар төгрөгөөр бэлтгэгдсэн. Энэ сууриар санхүүжилтийг олсон үед нь бус мөнгөөр хүлээн авсан үедээ санхүүжилт хэмээн хүлээн

зөвшөөрдөг ба зарцуулалтыг үүссэн үед нь бус мөнгөөр төлбөр хийсэн үед нь зарцуулалт хэмээн хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын хөрвүүлэлт

Тайлант жилд төгрөгөөс өөр валютаар хийгдсэн ажил гүйлгээнүүд нь гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлэгддэг. Ханшийн хөрвүүлэлтээс үүссэн ашиг, алдагдлыг санхүүжилт, зарцуулалтын тайланда хүлээн зөвшөөрдөг.

КЛАЙМ Монгол Олон Улсын Байгууллага нь санхүүгийн тайлангаа төв КЛАЙМ-ын журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн ‘Бусбро’ программ хангамж ашиглан бэлтгэдэг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ХУРААНГУЙ

Клайм Монгол Олон Улсын Байгууллагын Нягтлан Бодох Бүртгэл Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн хуулийн дагуу дараахь бодлогуудад суурilan бэлтгэсэн.

a. Санхүүжилт болон тууний зардлын тайлагнал

Энэхүү дүн нь Щвейцарийн Олон улсын КЛАЙМ –ээс санхүүжүүлж, төслийн нэгжийн хүлээн авсан санхүүжилтийг орлогын тайланда орлого буюу санхүүжилтээр илэрхийлнэ. Орлогоос банкны шилжүүлэгийн хураамжтай холбогдон гарсан зардлыг зардлаар тусган толилуулсан.

Тухайн жилд Төмс, Худаг төслийг зогсоож, Хонь төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Оюуны байр, Цэцэрлэг төслийг шинээр хэрэгжүүлсэн.

Хашаа 1, 2 төслийг тасралтгүй явуулж байна.

b. Бусад үйл ажиллагааний орлого

Клайм Монгол ОУБ-ын үйл ажиллагаагаар олсон орлогыг орлогын тайланда бусад үйл ажиллагааний орлогоор хуримтлуулан тайлагнасан.

c. Авлагын бүртгэл

КЛАЙМ МОНГОЛД ОУБ-н ажилтануудын авлагыг нэхэмжлэлийн дүнгээр тайлагнасан. Авлагад найдваргүй авлагын сан байгуулсан.

d. Үндсэн хөрөнгө болон тууний элэгдэл

Үндсэн хөрөнгийг өмнөх үеүдэд зардлаар тайлагнасан ба санхүүгийн тайланда илэрхийлээгүй байсан болно. Тухайн жилд худалдан авсан хөрөнгийг тайланда тусгаж шулуун шугамын аргаар элэгдүүлэн тооцоолж байна.

e. Зээлийн эргэлтийн сан

Зээлийг иргэд болон ажилтануудад олгодог бөгөөд олгосон зээлийг авлагаар бүртгэж, зээлийн эргэн төлбөрийг авлага бууруулан зээлдэгч бүрээр эргэн төлбөр хийсэн талаар зээлийн бүртгэл хөтөлдөг.

Зээлийн эргэлтийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого байхгүй байна.

f. Гадаад валютын хөрвүүлэлт

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, өөр төлбөрийг гадаад валютаас Монголын төгрөгт Монгол Банкны хаалтын ханшаар хөрвүүлэн санхүүгийн тайланда тайлагнасан.

Мөн хөрвүүлэлттэй холбоотой гадаад валютын ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн олз гарзаар бүртгэгдсэн. Үндсэн хөрөнгө болон эд хогшилыг худалдан авахад худалдан авсан өдрийн ханшаар валютыг хөрвүүлж, Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

g. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн болон түүнтэй адилтгах хөрөнгөд гар дээрх болон банкны дансан дахь мөнгөн хөрөнгийг багтаасан.

h. Ажилчдын тэтгэмж тэтгэлэг

Ажилчдын тэтгэмж тэтгэлэгт эрүүл мэндийн тэтгэмж, байгууллагаас төлөх НДШ багтаж байна. Эдгээр төлбөрүүд орлого үр дүнгийн тайланд зардлаар тайлагнагдсан.

3. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

	(төгрөг)
Кассанд байгаа бэлэн төгрөг	31/12/2012
Харилцах данс дахь мөнгө	35,177,100
Дүн	
	<u><u>35,177,100</u></u>

4. АВЛАГА

	(төгрөг)
Татварын авлага	31/12/2012
Дүн	22,200
	<u><u>22,200</u></u>

5. БУСАД ПАССИВ

	(төгрөг)	
	31/12/2011	31/12/2012
Дахин үнэлгээний нөөц	143,334,238	218,324,335
Дүн		
	<u><u>143,334,238</u></u>	<u><u>218,324,335</u></u>

6. УЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	(төгрөг)
Тээврийн зардал	31/12/2012
Бусад зардал	58,000
УЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u><u>252,000</u></u>
	<u><u>310,000</u></u>